

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДУНД ХУГАЦААНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

1.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх¹ гэмт хэрэг болон эдгээрийг үйлдэж буй гэмт бүлэглэлүүдтэй тэмцэх олон улсын стандартад нийцсэн тогтолцоо бий болгох, хөгжүүлэх замаар санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдлыг хадгалснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

2.1. Энэхүү хөтөлбөрийн 1.1-д заасан зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ:

2.1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог хангах;

2.1.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулж, үнэлгээ хийх;

2.1.3 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдлэг, мэдээллийг сайжруулах, санхүүгийн болон санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч салбарыг уг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.4 ФАТФ²-ын 40 зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг бий болгох;

2.1.5 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх³ хяналт шалгалтын хүрээг нэмэгдүүлэх;

2.1.6 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, гэмт хэргийн замаар олсон орлого, эд хөрөнгийг царцаах, битүүмжлэх чадавхийг бий болгох, хөгжүүлэх;

2.1.7 Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх;

2.1.8 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хянаж шийдвэрлэхэд шүүгч, прокурорын арга ажиллагаа, ур чадварыг дээшлүүлэх;

¹ Цаашид “МУТС” гэх

² Financial action task force (FATF)

³ Цаашид “МУТСТ” гэх

2.1.9 Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хүчин чадал, механизмыг бэхжүүлэх;

2.1.10 МУТСТ чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх, сургалт, семинарт тогтмол хамруулах;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3. Хөтөлбөрийг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

3.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1.1. МУТС эрсдэлийг салбар тус бүрээр тооцож дүн шинжилгээ хийх, холбогдох бодлого, журам боловсруулах;

3.1.2. ХАЗ⁴ нь Үндэсний стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлыг бодлогын болон үйл ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3. ХАЗ болон ТТАЗЗ⁵-ийн хамтын ажиллагааг зохицуулсан баримт үйлдэж мэдээлэл солилцоо болон холбогдох бусад үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.1.4. Үйл ажиллагааны болон салбарын түвшинд хамтын ажиллагаа, тусламж, уялдаа холбоог сайжруулах;

3.1.5. Бусад салбаруудын бодлого болон хөтөлбөрт МУТСТ арга хэмжээг шигтгэн оруулж хэрэгжүүлэх;

3.1.6. Бүс нутгийн болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар МУТСТ үндэсний чадавхийг сайжруулах;

3.1.7. МУТСТ чиглэлд хэрэгжүүлэгч байгууллагуудын чадамж, чадавхийг дэшлүүлэх зорилготой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1. МУТСТ тогтолцооны эрсдэлийн үнэлэгээ хийх ажлыг цэгцлэх, тодорхой болгох зорилгоор Үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулах;

3.2.2. Үйл ажиллагаандаа эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлж хэвшүүлэх. Салбар тус бүрийн эрсдэлийн түвшинд тулгуурлан урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах;

3.2.3. Монгол улсын МУТС эрсдэлийн талаар Санхүүгийн салбарын байгууллагууд болон Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) нарт бүрэн таниулж ойлгуулах;

⁴ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 22 дугаар зүйлд заасан Хамтын ажиллагааны зөвлөл

⁵ Террорзмтой тэмцэх тухай хуулийн 6.3-т заасан “Террорзмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл”

3.2.4. Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэх эрсдэлийн цогц судалгааг хийх;

3.2.5. Үнэлгээг хийх, мэдээлэл цуглуулах зорилгоор шаардлагатай тоо, мэдээний маягыг нэгдсэн форматад оруулж, боловсронгуй болгох;

3.2.6. Үнэлгээг тогтмол шинэчлэх, салбар тус бүрийн эрсдэлийн түвшинг тооцох зорилгоор холбогдох бүх байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлэх, тухай бүр шинэчлэх;

3.3. Гуравдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. МУТСТ хүрээнд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлснээр гарах эерэг үр дүн болон арга хэмжээг хугацаа алдалгүй авч хэрэгжүүлээгүйгээс үүсч болох эрсдэлийн талаар Засгийн газрын бодлого боловсруулагчид болон удирдах албан тушаалтнуудад мэдлэг, ойлголт өгөх уулзалт, хэлэлцүүлэгийг тогтмол хийх;

3.3.2. Хяналт шалгалт, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил явуулах байгууллага, прокурор, шүүхйн ажилтнуудад зориулан МУТС тухай ойлголт, мэдлэг өгөх сургалтын хөтөлбөрийг олон улсын жишиг түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх;

3.3.3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зорилтот салбаруудад чиглэсэн мэдлэг, ойлголт өгөх ажлыг тогтмол хийх;

3.3.4. Шүүх, прокурор, цагдаа, гааль, татвар болон санхүүгийн байгууллагуудын түвшинд санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой чиглэлээр хийгдэж буй сургалт, мэдээлэлийг нэмэгдүүлэх, энэ ажлын төлөвлөгөөний биелэлтэд тогтмол мониторинг хийх;

3.3.5. МУТСТ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу тайланг тогтмол гаргаж байх. МУТСТ ойлголт, мэдлэг өгөх сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй байдлын талаар үнэлгээ хийх;

3.3.6. СЗХ өөрийн хариуцсан санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-д дэх МУТСТ үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалтыг сайжруулах, тэдний МУТС эрсдэлийн талаарх мэдлэг ойлголт, МУТСТ үүрэг хариуцлагын хэрэгжилтийг сайжруулах;

3.3.7. Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн мэдээллийн алба⁶ хамтран МУТС эрсдэлүүдийг удирдах зорилгоор СББМҮҮ салбар (хуульчид, нягтлан бодогчид, үнэт эдлэлийн дилерүүд гэх мэт), ялангуяа үндэсний эрсдэлийн үнэлгээгээр эрсдэл өндөртэй гэж тодорхойлогдсон салбаруудыг хянах, зохицуулахад хүчин чармайлт гаргах;

3.3.8. Хянан шалгагч байгууллагууд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн МУТС гэмт хэргийн эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, МУТСТ үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх. Тухайлбал:

⁶ Цаашид “СМА” гэх

- Салбарын холбоод болон өөрөө удирдах байгууллагуудын тусламж дэмжлэг авч ажиллах ажлыг эрчимжүүлэх;
- Салбарын онцлогт нийцсэн (а) мэдээлэгч этгээдүүдийн эрсдэлд суурилсан үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг, (b) үр ашиг хүртэх, хариуцах эзэн, (c) төрийн байгууллагууд болон (d) терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, бууруулах зэрэг чиглэлээр заавар, удирдамж гаргах.

3.3.9. СМА-наас мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд сэжигтэй гүйлгээний тайланг гаргаж ирүүлэх үүргээ биелүүлэхэд чиглэл өгч, сэжигтэй гүйлгээг таних, тайлагнах чиглэлд туслах;

3.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.4.1. МУТСТ хууль, эрх зүйн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор хянаж судлах;

3.4.2. МУТС-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой санхүүгийн болон СББМҮҮ-дийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах, тэдгээрт МУТС-ийн эсрэг хууль эрх зүй болон зохицуулалтын шаардлагыг хэрэгжүүлээгүйн төлөө авах хариуцлагын арга хэмжээг өндөрсгөх;

3.4.3. МУТС-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хуулийн этгээд, итгэлцэл, ТББ болон зарим СББМҮҮ нарын бүртгэл, зөвшөөрөл олгох, ил тод байдлыг хангах, зохицуулалт, хяналт шалгалттай холбоотой өргөн хүрээтэй хууль эрх зүйн орчинг бий болгох;

3.4.4. МУТС, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, тэдгээртэй холбоотой хөрөнгийг илрүүлэхэд, царцаахад, хянахад, хураахад, хилийн чанадаас буцаан татах, удирдахтай холбоотой арга хэмжээг авах олон улсын стандартад нийцсэн хууль эрх зүйн орчныг бий болгох, эдгээр гэмт хэргүүдтэй холбоотой санхүүгийн болон үйл ажиллагааны хориг арга хэмжээ авах эрхийг холбогдох байгууллагуудад нээлттэй болгох;

3.4.5. МУТС-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвшөөрөлгүй мөнгөн гуйвуулга, электрон санхүүгийн гүйлгээ, бэлэн мөнгө болон бэлэн бус санхүүгийн хэрэгслийг хилээр давуулах үйл ажиллагааг хянахтай болон үнэт метал, үл хөдлөх хөрөнгө гэх мэт өндөр үнэтэй эд зүйлсийн арилжааг албан ёсны зах зээлд оруулахтай холбоотой олон улсын стандартад нийцсэн хууль эрх зүйн орчныг бий болгох;

3.4.6. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх Монгол Улс гишүүнээр орсон НҮБ-ын гэрээ, конвенц, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн болон бусад олон улсын байгууллагын тогтоолуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг бий болгох;

3.4.7. МУТС болон холбогдох бүхий бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг мөрдөн шалгах, шүүхийн хяналтад байлгахтай холбоотой хууль эрх зүйн шаардлагатай зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.5. Тавдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.5.1. Хянан шалгагч байгууллагууд нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээр МУТСТ үүргийг дагаж мөрдүүлэх, хэрэв үүргээ биелүүлэхгүй тохиолдолд авах хариуцлагын механизмыг тодорхой болгож, хэрэгжүүлэх;

3.5.2. Хянан шалгагчид мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд МУТСТ-д тэдний гүйцэтгэх үүрэг хариуцлага, үүсч болзошгүй эрсдэлүүд, түүнийг бууруулахад анхаарах асуудлын талаар ойлголт өгөхөд зайлшгүй шаардлагатай гарын авлага, материалыг гаргаж хүргүүлэх;

3.5.3. Хянан шалгагч байгууллагууд техникийн түвшинд мөрдөх шаардлагатай боловч орхигдсон зохицуулалтуудыг МУТСТ тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичигт оруулах;

3.5.4. СЗХ нь МУТСТ эрсдэлд суурилсан (зайнаас болон газар дээрх) хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэх, өөрийн зохицуулдаг салбар бүрийн хувьд цогц эрсдэлийн үнэлгээ хийх;

3.5.5. СЗХ хяналтын үүргээ үр дүнтэй биелүүлэхэд шаардлагатай зайны болон газар дээрх хяналт шалгалт явуулах цахим систем, бусад техник хангамжийг боловсронгуй болгож, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, хяналт шалгагчдыг өргөжүүлэх;

3.5.6. СЗХ-ны зохицуулалтанд хамаарах үйл ажиллагааг зөвшөөрөлгүй, тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд тавих хяналт шалгалтыг сайжруулах;

3.5.7. Хянан шалгагчид мэдүүлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд илэрсэн МУТСТ-тэй холбоотой зөрчлийг арилгуулах болон тайлагналыг сайжруулахын тулд өөрсдийн албадлагын эрх мэдлийг зохистой түвшинд хэрэглэхийг хэвшүүлэх;

3.5.8. МУТС гэмт хэргийг илрүүлэхэд хянан шалгагч, эрх бүхий албан тушаалтан, ХСБ-ын ажилтануудыг хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

3.5.9. Хянан шалгагчид бүх мэдээлэх үүрэгтэй этгээдүүдтэй илүү өргөн хүрээнд хамтран ажиллах. Тухайлбал, байнгын уулзалт хийх, МУТСТ чиглэлд сургалт, хэлэлцүүлэг болон семинар зохион байгуулах, холбогдох материал, сайн туршлагын талаарх товхимол хүргүүлэх болон хувийн сектортой илүү үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох зорилгоор тэдгээрт холбогдох бичиг баримтын төслийг бэлтгэх үед тухайн салбарын төлөөллийг оролцуулах зохицуулалт бий болгох;

3.5.10. ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мэдээлэх үүрэгтэй этгээдийн жагсаалтад үнэт эдлэлийн дилерүүд, нягтлан бодогчид зэрэг СББМҮҮ-дийг нэмж оруулах;

3.5.11. Харилцагчдаас тодруулга авах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, мэдээ баримтыг хамгаалах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, дансны хяналт болон бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тухайн байгууллага, мэргэжлийн онцлогт тохируулж, олон улсын стандартад нийцүүлэн тодорхойлж хэрэгжүүлэх;

- 3.5.12. МУТСТ тогтолцоо муу өндөр эрсдэлтэй улс орнуудтай харилцаж байгаа аливаа харилцаанд тавих хяналтын нэгдсэн аргачлал шат шатанд бий болгох;
- 3.5.13. МУТС-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн биелэлтийг хангуулах зорилгоор байнгын ажиглалт, хяналт шалгалт, мониторинг хийх тогтолцоог бий болгох;
- 3.5.14. Хууль, эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдөөгүй мөнгөн гуйвуулга хийх системүүд байгаа эсэхийг шалган тогтоож, үйл ажиллагааг хориглох;
- 3.5.15. Хянан шалгагч байгууллагуудын институци, мэргэжлийн экспертиз болон ажилчдын чадавхийг өндөржүүлэх замаар зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулах;
- 3.6. Зургаадугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
- 3.6.1. СМА-ны үйл ажиллагаанд хөндлөнгийн зүй бус нөлөө орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор түүний эрх хэмжээ, үйл ажиллагааны зохицуулалтыг олон улсын ижил төрлийн байгууллагуудын стандартад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж баталгаажуулах;
- 3.6.2. СМА-ны дүн шинжилгээ хийх аргачлалыг шинэчлэн сайжруулж, стратеги дүн шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлэх;
- 3.6.3. СМА-ны дүн шинжилгээ хийх үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийг олон улсын жишигт хүрэхүйц болгож дээрх үйл ажиллагааны өгөөжийг дээшлүүлэх. Тухайлбал, өргөн хүрээг хамарсан, цогц програм хангамжтай болгох;
- 3.6.4. СМА-ны ажилтнуудын орон тоог нэмэгдүүлэх, дүн шинжилгээ хийх мэргэжлийн ур чадвар, чадавхийг дээшлүүлэх, сургалт, семинарт тогтмол хамруулах;
- 3.6.5. СМА-ыг Монгол улсын МУТС эрсдэлд суурилсан, ХСБ-уудын хэрэгцээ шаардлагад нийцсэн стратеги дүн шинжилгээ хийдэг болгох;
- 3.6.6. Дотоодын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх үйл ажиллагааны болон стратеги дүн шинжилгээнд ашиглагдах мэдээ мэдээллээр СМА-ыг боломжит өргөн хүрээнд хангах;
- 3.6.7. Хууль сахиулах салбарын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан мөнгө угаах өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа СМА-ны дүн шинжилгээний үр дүн болон мэдээллийг түлхүү ашиглах;
- 3.6.8. СМА нь ХСБ-ын хамт МҮЭ-ийн МУТСТ чиглэлээр мөрдөж байгаа журам, зааврыг тодорхой давтамжтайгаар хянаж, шаардлагатай тохиолдолд тухайн үеийн олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөн батлуулж байх;
- 3.6.9. СМА нь холбогдох бусад төрийн байгууллагууд болон МҮЭ-д МУТСТ арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл өгч, холбогдох сургалт зохион байгуулж байх;

3.6.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааг сайжруулах, зохих арга хэмжээг авах чадавхийг бий болгох;

3.6.11. МУТС-тэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгахад зориулсан зохицуулалтын механизм бий болгох тал дээр арга хэмжээ авах. Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн өндөр эрсдэлтэй чиглэлд нөөц хөрөнгийг түлхүү хуваарилах;

3.6.12. Мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил, тагнуул, прокурор, шүүхийн байгууллагын албан хаагч нарыг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны сургалтад тогтмол хамруулах;

3.6.13. Гэмт хэргээс олсон орлогыг хураах, битүүмжлэх чиглэлээр хууль сахиулах болон шүүх, прокурорын байгууллагын албан хаагч нарыг тогтмол сургалтанд хамруулах;

3.6.14. Хил дамнан үйлдсэн гэмт хэргийн орлогыг битүүмжлэх, хураах, буцаан авах чиглэлээр гүйцэтгэх ажлын мэдээллийн чанарыг нэмэгдүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны бүрдэлийг сайжруулж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхижүүлэх;

3.6.15. Хуулийн болон хяналтын тогтолцооны хамрах хүрээнд хилээр дамжиж буй бэлэн мөнгө, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл, үнэт метал болон үнэт эдлэлийг илүү тодорхой болгож оруулах;

3.6.16. МУТС болон холбогдох үндсэн гэмт хэргүүдийн арга хэрэгсэл, олсон орлогыг мөрдөх, илрүүлэх, түдгэлзүүлэх болон хураан авах бодлого, журам боловсруулж хэрэгжүүлэх.

3.6.17. МУТС гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгахад олон улсын стандартад нийцэхүйц үйл ажиллагааны журам, заавар боловсруулж мөрдөх;

3.6.18. Хилээр дамжих магадлалтай хууль бус эд хөрөнгийг мөрдөх, илрүүлэх, түдгэлзүүлэх болон хураан авах чиглэлд хилийн хяналтыг сайжруулах, мөн холбогдох байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоог хөнгөвчлөх механизм боловсруулах;

3.7. Долоодугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.7.1. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой эрсдэлийг тогтоож, түүний дагуу урьдчилан сэргийлэх цогц бодлого, үйл ажиллагааны чиглэл боловсруулах;

3.7.2. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг заавал бүртгүүлэхийг хуулиар шаарддаг болох;

3.7.3. Хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагууд арга хэмжээ авах;

3.7.4. ФАТФ-аас гаргасан ТББ-ын тухай тодорхойлолтод ямар төрлийн байгууллагуудыг хамааруулах талаар шийдвэр гаргаж тодорхой болгох;

3.7.5. ТББ-ын терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой болон ТББ-ууд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн золиос болох эрсдэлийг тооцох, түүнд үндэслэн зохих арга хэмжээг авах;

3.7.6. Терроризмыг санхүүжүүлдэг байх магадлалтай ТББ-уудын төрөл, шинж чанарыг тодорхойлохдоо холбогдох бүх төрлийн мэдээллийн эх сурвалжийг ашиглах;

3.7.7. Шашны болон ТББ-уудад террорист этгээдүүдээс үзүүлж буй эсвэл үзүүлж болзошгүй аюул занал, дарамтын мөн чанарыг тодорхойлж, үндэсний эрсдэлийн үнэлгээнд тусгах;

3.7.8. Тодорхойлогдсон эрсдэлүүдийг онцлох зорилгоор МУТС үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй ТББ-уудад авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох;

3.7.9. ТББ-уудад хяналт, шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэх;

3.7.10. МУТС гэмт хэрэг, авлигаас урдчилан сэргийлэх зорилгоор хуулийн этгээдийн засаглалын дүрэм, журмыг боловсрогуй болгож сайн засаглалыг хөгжүүлэх;

3.7.11. МУТС, түүний боломжит хор уршигийн талаар шашны болон ТББ-уудад тодорхой ойлголт, мэдээлэл өгдөг байх;

3.7.12. ТББ-уудыг аливаа гүйлгээг бүртгэлтэй санхүүгийн байгууллагуудаар дамжуулж байхыг дэмжих;

3.7.13. ТББ-ын тухай хуулийн 8 болон 24 дүгээр зүйлд заасан хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн байдлаар хүлээлгэх зохицуулалт бий болгох;

3.7.14. Террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагатай холбоотой эсвэл энэ төрлийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжигч байж болзошгүй ТББ-уудыг мөрдөн шалгах Тагнуулын ерөнхий газрын чадавхийг нэмэгдүүлэх;

3.8. Наймдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.8.1. ХСБ-ууд хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр МУТС болон бусад гэмт хэргийг мөрдөн шалгахтай холбоотой хууль сахиулагчдын чадавхийг бэхжүүлэх;

3.8.2. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээд болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон бусад этгээдүүдэд ял оногдуулах тогтолцоог сайжруулах;

3.8.3. Гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан ил болон нуугдмал хөрөнгө, орлого, тэдгээрийн эх үүсвэрээр бий болсон бусад төрлийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй байдлыг хангах зорилгоор битүүмжлэх, захиран зарцуулах эрхийг хязгаарлах, хураан авах ажиллагааг эмчимжүүлэх;

3.8.4. Хууль сахиулах байгууллагын МУТС гэмт хэргийн гаралтай хөрөнгийг битүүмжлэх, хураахтай холбоотой үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох зорилгоор энэ чиглэлийн үүрэг бүхий бүтцийг шинээр бий болгох эсвэл түүнийг бэхжүүлэх;

- 3.8.5. Битүүмжилсэн болон хураан авсан хөрөнгийг үр дүнтэй удирдах, хуваарилах;
- 3.8.6. Хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудаас ажлын хэсэг байгуулж МУТС гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах аргачлал, гарын авлага, заавар, журам боловсруулж, хамтарсан тушаалаар батлуулах;
- 3.8.7. МУТС болон энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх үед үйлдэгдсэн бусад гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, таслан зогсоох зорилго бүхий мөрдөн шалгах байнгын ажиллагаатай ажлын хэсгийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагуудаас байгуулах;
- 3.8.8. Хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын төсөвт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, таслан зогсоох, тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж тогтооход шаардлагатай байцаан шийтгэх болон гүйцэтгэх ажлын зардал тусгуулах. Гэмт хэргээс олсон орлогыг хураан авч улсын төсөвт төвлөрүүлсэний дараа хууль сахиулах байгууллагуудад хуваариладаг олон улсын туршлагыг нутагшуулах;
- 3.8.9. Гэмт хэргийн эсвэл терроризмыг санхүүжүүлэх зорилгоор олсон орлого, хөрөнгийг хууль бусаар хил дамнуулах, гадаад улс руу эсвэл гадаад улсаас шилжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, шалгахтай холбоотой хууль сахиулагчдын чадавхийг бэхжүүлэх, нөөцийг зөв зохистой хуваарилах;
- 3.9. Есдүгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
- 3.9.1. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх болон ялтан шилжүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- 3.9.2. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх журмыг баталж, мөрдүүлэх;
- 3.9.3. Үндэстэн дамнасан гэмт хэргүүдийн мөрдөн байцаалтыг дэмжсэн эрх зүйн харилцан туслалцаа хүлээн авах болон үзүүлэх ажлыг эрчмжүүлэх;
- 3.9.4. МУТС гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах санаачлага гаргаж, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох (Энэ төрлийн гэрээ байгуулагүй Швейцарийн холбооны улс, ИБУИНВУ, БНХАУ-ын тусгай бүс Хонгконг, татварын хөнгөлттэй оффшор бүс дэх бусад улсууд зэрэг орно) ;
- 3.9.5. МУТС болон холбогдох гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүхтэй холбоотой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтүүдийн шуурхай байдлыг хангахын тулд холбогдох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;
- 3.9.6. МУТС болон бусад үндэстэн дамнасан гэмт хэргийн талаарх мэдээллийн үр дүнтэй солилцоог дэмжин сайжруулахын тулд холбогдох байгууллагууд болон тэдгээрийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, чадавхийг сайжруулах;
- 3.9.7. Үйл ажиллагааны түвшинд бүс нутгийн болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, харилцан туслалцааг бэхжүүлэх;

3.9.8. МУТС-ийг мөрдөн шалгах, яллахад ашиглагдах үндэсний бүртгэлийн системийг бий болгох;

3.10. Аравдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.10.1. Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд МУТС-тэй тэмцэх чиглэлийн сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах;

3.10.2. МУТСТ чиглэлээр хянан шалгалт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, тогтмол сургалт, семинарт хамруулах;

3.10.3. Хууль сахиулах, шүүх, прокурорын байгууллагын албан хаагч нарыг мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх;

3.10.4. Гааль, татварын байгуулагуудын албан хаагч нарыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүлэхтэй тэмцэх чиглэлээр чадавхижуулах;

3.10.5. Гэмт хэргээс олсон орлогыг хураах, битүүмжлэх чиглэлээр хууль сахиулах болон шүүх, прокурорын байгууллагын албан хаагч нарыг чадавхижуулах;

3.10.6. Эрсдэлийн үнэлгээнд суурилан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийг зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд МУТСТ-тэй холбоотой оролцогч байгуулагуудын чадавхийг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх;

3.10.7. Олон нийтийн МУТСТ талаарх мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

3.10.8. БСШУСЯ-наас МУТСТ тухай ойлголт, ухагдахууныг бүх шатны боловсролын системд оруулах, бага, дунд, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгах боломжийг судалж, үр дүнд тулгуурлан холбогдох арга хэмжээг авах;

3.10.9. МУТСТ талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр гол зохицуулагч байгууллагууд идэвхи, санаачлагатай ажиллах;

3.10.10. Шат шатанд зохион байгуулагдах сургалт, семинарын давтамж, агуулга, хэлбэр (брошур, сонин, хэвлэл г.м)-ийг тухайн сургалтад хамрагдаж буй этгээдүүд (улс төрчид, хувийн хэвшил, иргэд, төрийн байгууллагууд, г.м)-д нийцүүлэн бэлтгэхэд бүх тал анхаарч ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа, хүрэх үр дүн

4.1 Хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

4.2 Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ:

4.2.1 МУТСТ холбогдох байгууллагууд хоорондын болон төр, хувийн хэвшлийн ажлын уялдаа холбоо сайжирна. МУТСТ чиглэлээр үндэсний хэмжээний үйл ажиллагаа зохион байгуулдаг болно;

4.2.2 Шүүх эрх мэдлийн, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, СББМҮҮ-д болон олон нийтийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт нэмэгдэж МУТСТ чиглэлээр явуулах үйл ажиллагаа сайжирч, мэдээлэл солилцох, шалгах ажил илүү үр дүнтэй болно;

4.2.3 Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-д өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон МУТС эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ СМА-д хүргэх сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо өсөхөөс гадна түүний чанар, агуулга сайжирна. Үүнийг дагаад ХСБ-д очих мэдээлэл чанаржих болно;

4.2.4 Мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх НҮБ, ФАТФ зэрэг олон улсын байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн хууль эрх зүйн тогтолцоотой болно;

4.2.5 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийг МУТСТ үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, зохицуулах цогц тогтолцоотой болно;

4.2.6 СМА-ны үйл ажиллагаа өргөжиж, хууль сахиулах байгууллагад хүргэгдэх мэдээллийн чанар сайжирч урсгал нь өргөжих болно. МУТС гэмт хэрэг нь үндсэн гэмт хэрэг болж, хууль сахиулах, шүүхийн байгууллагуудын боловсон хүчнийг энэ чиглэлээр дадлагажуулснаар тус гэмт хэргийн илрүүлэлт, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо нэмэгдэнэ;

4.2.7 МУТС хууль бус үйлдлээс хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг урьдчилан сэргийлж, эрх бүхий байгууллага нь тэдгээрийн эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг саадгүй авдаг болно;

4.2.8 Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгчийг хөрөнгө мөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх орчин бүрдэхээс гадна шашны болон төрийн бус байгууллагуудыг хууль бус үйл ажиллагаанд татан оруулах, урвуулан ашиглах боломжгүй болно;

4.2.9 МУТС болон холбогдох бусад гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, гэмт хэрэгтнүүдэд тохирсон цээрлүүлэх ял шийтгэл оногдуулах бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.2.10 Үндэстэн дамнасан гэмт хэргүүдийн мөрдөн байцаалтыг дэмжсэн харилцан туслалцаа хүлээн авах болон үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

4.2.11 Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гэмт хэрэгтэн болон тэдний хөрөнгийн талаар шаардлагатай мэдээ, санхүүгийн мэдээлэл болон нотлох баримтыг олох бүрэн боломжтой болно;

4.2.12 МУТСТ тухай иргэд, олон нийтийн мэдлэг, мэдээлэл, ойлголт нэмэгдэж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын чадавхи, тэдгээрийн хоорондох харилцан хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирснаар үндэсний хэмжээнд МУТС гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх суурь орчин бүрдэнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө;

5.1.3. Бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт, тайлагналт

6.1. Үндэсний зөвлөл⁷ хөтөлбөрийг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

6.1.1. Арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн зорилт тус бүрийн хувьд гол анхаарах асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хүлээгдэх үр дүн, хэрэгжүүлж дуусах хугацаа, манлайлан хэрэгжүүлэх байгууллага, хамтран оролцогч байгууллага болон шаардлагатай эх үүсвэрийг хаанаас хариуцах байдлаар боловсруулах болно.

6.1.2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэхүү арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллага тус бүрийн хариуцан хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болгон зохион байгуулах ёстой болно. Энэ ажлыг Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ) - ийн түвшинд гүйцэтгэж, хэрэгжилтэд хяналт тавина.

6.1.3. Энэхүү үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд Монгол Улсын Засгийн газар шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулснаар хугацааг сунгаж болно.

6.1.4. Үндэсний зөвлөл (ҮЗ) нь үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хянах, үнэлэх болон хэрэгжилтийн үнэлгээний үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах ажлыг хариуцна.

6.1.5. ҮЗ нь Хамтын ажиллагааны зөвлөлтэй хамтран үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний эрсдлийн үнэлгээ, холбогдох тайлангуудын зөвлөмж, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт зэрэгт үндэслэн жил бүр хянана. Зорилтыг манлайлан хариуцах байгууллагууд нь тухайн зорилт, түүний арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг ҮЗ-ийн хуралдаанд тайлагнана. Тус зөвлөл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, шаардлагатай тохиолдолд зохих өөрчлөлт, тодотгол оруулна. Өөрчлөлт оруулахдаа олон улсын байгууллагуудаас гаргасан МУТСТ-тэй холбоотой стандарт, жишээ болохуйц сайн туршлага зэргийг харгалзан үзнэ. Иймд энэхүү хөтөлбөр нь динамик буюу МУТС эрсдэлүүд, эдгээр эрсдэлтэй тэмцэхэд гарч буй дэвшлийг тусгасан байдлаар тухай бүр шинэчлэгдэж байх “амьд” бичиг баримт байна.

⁷ Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаар захирамжаар байгуулагдсан.

6.1.6. МУТСТ үндэсний хөтөлбөр, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон бусад эх үүсвэр, түүний хувиарлалтыг Монгол Улсын Засгийн газар хариуцна.